



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 15 өдөр

Дугаар АЖК

Хэрлэн сум

Залуучуудад зориулсан үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх зорилгоор зохион байгуулах үйл ажиллагааны лед дэлгэцийн ашиглалт, хамгаалалтын зардалд 2,548,800 (хоёр сая таван зуун дөчин найман мянга найман зуу) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
... дугаар сарын ... -ны өдрийн
... дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1.	Лед дэлгэцийн харуул хамгаалалт	Хоног	15	100,000	1,500,000
2.	Лед дэлгэц ажиллуулах ажилтаны хөлс	Хүн	1	500,000	500,000
3.	Суурин утас, КТВ гурвалсан үйчилгээний төхөөрөмж	ширхэг	1	548,800	548,800
Нийт					2,548,800